



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 9/304

Арвайхээр сум

Комисс томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хархорин сумын 2 дугаар багт байрлах “Хархорин өргөө” ХХК-ийн захиалгаар баригдсан 1 давхартаа үйлчилгээтэй 5 давхар 25 айлын орон сууцны барилга угсралтын ажил дууссан тул “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу бага төвөгшилтэй барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дарга (А.Энхцэцэг)-д даалгасугай.

ОРЛОГЧ

И.ДОРЖСҮРЭН



6223 11 0578

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар
сарын 11-ны өдрийн 10:00 дугаар
захирамжийн хавсралт

**БАГА ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: А.Энхцэцэг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлстийн дарга)

Гишүүд:
С.Нямдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)

Ц.Нэргүй (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Б.Өсөхбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Ахмад)

Э.Базардаарий ("Хархорин-Ус суваг" ОНӨААТҮГ-ын ашиглалтын инженер)

Ш.Бат-Орших (Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Хархорин салбарын инженер)

Д.Оюунчимэг ("Монголын цахилгаан холбоо" ТӨХК-ийн Өвөрхангай аймаг Хархорин сумын салбарын эрхлэгч)

Г.Найманжин ("Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн Өвөрхангай аймгийн газрын Хархорин салбарын эрхлэгч)

Ц.Оюунтунгалаг (Өвөрхангай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн)

Ашиглагч:
Э.Очир-Эрдэнэ (Хархорин сумын архитектор)

Захиалагч, гүйцэтгэгч: Ю.Хандмаа ("Хархорин өргөө" ХХК-ийн захирал)

Зураг төсөл гүйцэтгэгч: Б.Уламбаяр ("Жигүүрт хөлөг" ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга: Ц.Нямдалай (аймгийн Засаг даргын эрхлэх асуулдлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн)